



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/Н/8

Мандалговь

Хариу арга хэмжээ, тандалт судалгаа,
Санхүү, нөөц хангалтын баг томилон ажиллуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын (б), Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн нутаг дэвсгэрт үүссэн Ковид-19 цар тахлын үед аймгийн Онцгой комиссын дэргэд ажиллах хариу арга хэмжээ, тандалт судалгаа, санхүү, нөөц хангалтын багийг нэгдүгээр хавсралтаар, багийн хэрэгжүүлж ажиллах ажлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хариу арга хэмжээг цаг алдалгүй тухай бүр нь авч Онцгой комиссын гишүүдийг мэдээ, мэдээллээр ханган, шийдвэр гаргахад шаардлагатай саналыг танилцуулах, Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, бүлгүүд, иргэдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг багийн ахлагч (А.Нарантуяа, Г.Энхтайван) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481210413